



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/27

Өвт

Тамхи худалдах тусгай зөвшөөрөл
сунгах тухай

Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 7.3 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 16 дугаар зүйлийн 16.3.4, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Бат-Өлзий сумын нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Н.Болдбат эзэнтэй "Мөнх хайрхан", Н.Өлзийбаяр эзэнтэй "Өөдрөг", Х.Нямлхагва эзэнтэй "Оргил", П.Анхбаттар эзэнтэй "Амт" хүнсний дэлгүүрүүдэд тамхи худалдах тусгай зөвшөөрлийн хугацааг 2 жилийн хугацаатай сунгасугай.

2. Тамхи худалдаалах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамж 100000 (Нэг зуун мянган) төгрөгийг сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэхийг Гааль, татварын улсын байцаагч (Н.Батсайхан)-д даалгасугай.

3. Тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгогдсон дэлгүүрийн үйл ажиллагаанд хяналт тавьж үр дүнг тооцон ажиллахыг Цагдаагийн хэсгийн дарга, Цагдаагийн хошууч (З.Мягмарсүрэн), Гааль, татварын улсын байцаагч (Н.Батсайхан), Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч (П.Аюушжав) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

М.ЖАМЪЯНШАРАВ



D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/

051010053